

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ 8 ДУГААР САРЫН ХУРЛАА ХИЙЛЭЭ

Монголын Банкны Холбооны дэргэдэх Эрсдэлийн удирдлагын мэргэжлийн зөвлөлийн хурал 2018 оны 8 дугаар сарын 10-ны өдөр буюу өнгөрөгч баасан гаригт 8 дугаар сарын хурлаа хийлээ.



Уулзалтын эхэнд Эрсдэлийн Удирдлагын мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 7 сарын 20-ны өдрийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийн байдал, хүлээгдэж буй ажлууд болон Монголбанкны боловсруулж буй журам, эрх зүйн актын талаар мэдээлэл өглөө. Төлөвлөгөөний дагуу Хаан банкны Эрсдэл хариуцсан дэд захирал Чибя Чикос "Эрсдэлийн удирдлагын хүрээ, засаглал" сэдвээр, Улаанбаатар хотын банкны Эрсдэлийн удирдлагын газрын Зах зээлийн эрсдэлийн мэргэжилтэн Б.Долгоржав "Эрсдэлийн аппетит" сэдвээр тус тус танилцуулга хийж, харилцан туршлагаасаа хуваалцсан ба асуулт тодруулгад хариу өгөв.



Идэвхтэй хамтран ажиллаж байгаа Эрсдэлийн удирдлагын мэргэжлийн зөвлөлийн нийт гишүүддээ талархал илэрхийлж, цаашид олон талаар хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

МАРКЕТИНГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ ШИНЭ ДАРГАТАЙ БОЛЛОО

Маркетингийн мэргэжлийн зөвлөлийн ээлжит хурал 2018 оны 8 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулагдлаа. Уулзалтаар цаг үеийн асуудлаар хэлэлцэж, банкны салбарын үйл ажиллагааны онцлог, бүтээгдэхүүн үйлчилгээний суурь ойлголтыг олон нийтэд үнэн зөвөөр таниулах чиглэлээр банкууд хэрхэн хамтран ажиллах боломжтой талаар санал бодлоо хуваалцаж, цаашид хийгдэх ажлуудаа ярилцлаа.



Тус мэргэжлийн зөвлөлийн дарга, ХХБ-ны Маркетингийн газрын захирал Б.Баярмаа Гүйцэтгэх захирлын орлогчоор дэвшин ажиллах болсон тул МБХ-ны журмын дагуу дахин сонгууль явуулж, Голомт банкны Маркетингийн хэлтсийн захирал С.Идэр мэргэжлийн зөвлөлийн даргаар сонгогдлоо. С.Идэр захирлын хувьд өнгөрсөн хугацаанд тус мэргэжлийн зөвлөлөөс хэрэгжүүлсэн "Бид-Банкир" аян болон бусад олон ажлыг амжилттай удирдан ажилласан юм.

Маркетингийн мэргэжлийн зөвлөлийн даргаар шинээр сонгогдсон С.Идэр захирал болон ХХБ-ны Гүйцэтгэх захирлын орлогч Б.Баярмаа захирал нартаа ажлын амжилт хүсье.

RESEARCH



ЦАХИМ БАНКНЫ МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА

Цахим банкны мэргэжлийн зөвлөлийн хурал 2018 оны 8 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулагдаж, картын гүйлгээний аюулгүй байдлын талаар хэлэлцлээ. Уулзалтаар Монгол Улсад хамгийн түгээмэл хэрэглэгддэг Т-карттай холбоотой луйврын гүйлгээ нэмэгдэх хандлагатай байгааг дурдаж, энэхүү хууль бус үйл ажиллагаанд гадаадын үл бүтэх этгээдүүдийн оролцоо байгааг онцоллоо. Тиймээс цаашид картын гүйлгээний аюулгүй байдлыг хангахад банкууд нягт хамтран ажиллахаас гадна зохицуулагч байгууллагын зүгээс дэмжлэг шаардлагатай болж байна.

Түүнчлэн МБХ-ны бусад мэргэжлийн зөвлөлүүдтэй хамтран ажиллаж, харилцагчид болон КҮБ-үүдэд чиглэсэн аюулгүй байдлын зөвлөмж, зааварчилгааг боломжит сувгуудаар хүргэх нь харилцагчийн боловсролыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж дүгнэлээ.

Хамгийн энгийн боловч үр дүнтэй арга нь картын нууц дугаарыг харилцагч өөрөө төхөөрөмжид оруулж хэвших, банкны ажилтнууд ойр дотны хүмүүстэй мөн үүнийг зөвлөх юм. Ингэснээр гэмт этгээдүүд картын мэдээллийг ямар нэг аргаар хуулбарлаж авсан ч, харилцагчийн данснаас зарлага гаргах боломжгүй болох юм.



БНСУ-ЫН АКТИВЫН УДИРДЛАГЫН КОМПАНИ "КАМСО" ТУРШЛАГАА ХУВААЛЦАНА

Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд Солонгосын Активын удирдлагын компаниас манай арилжааны банкуудад зориулан KAMCO (Korea Asset Management Corporation) активын удирдлагын үйл ажиллагааны туршлага, мэдээллийг солилцох "Banking Sector Rehabilitation and Strengthening Financial Stability in Mongolia" сэдэвт 1 өдрийн сургалт семинарыг зохион байгуулах гэж байна.

Тус семинарын арга хэмжээ нь 2018 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн Лхагва гарагт зохион байгуулагдах ба арилжааны банкууд болон төрийн байгууллагуудын төлөөлөл оролцож, активын удирдлагын компанийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээ, засаглал, санхүүжилт зэргийн талаар түлхүүр мэдээллийг олж авна. Түүнчлэн, хувийн болон төрийн активын удирдлагын компанийн ялгаа, тус бүрийн давуу, сул талуудыг харьцуулж, ижил үүрэг бүхий бүтцийг Монгол Улсад шинээр үүсгэн байгуулахад анхаарах асуудлуудын талаар ойлголтоо нэгтгэнэ.

ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛААР Г.ОДОНТУУЛ ТОМИЛОГДЛОО



ҮХОБ-ны ТУЗ-ийн 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрээр тус банкны Гүйцэтгэх захирлаар Г.Одонтуул томилогдон ажиллаж байна. Тус банкны Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Б.Тулга цаашид банкныхаа ТУЗ-ийг удирдан ажиллахаар болжээ.

ҮХОБ-ны Гүйцэтгэх захирлаар шинээр томилогдсон Г.Одонтуул, тус банкны ТУЗ-ийн даргаар сонгогдсон Б.Тулга нартаа ажил үйлс нь өөдрөг, амжилт бүтээлээр манлайлж явахыг хүсэн ерөөе.

МОНГОЛЫН БАНКНЫ ХОЛБОО

This message contains graphics. If you do not see the graphics, click [here](#) to view the full e-newsletter.

This newsletter was sent to you because you are registered to receive updates and special promotions from MBA. To opt out, click [here](#).